

## **ОЮУНЫ ӨМЧИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЖИЛЛАХ ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

### **Нэг. Журмын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсад иргэний бүтээл туурвих, бүртгэж баталгаажуулах, үр шимийг нь хүртэх эрхийг хамгаалах, тэдгээрийг ашиглахтай холбогдсон харилцааг Патентын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулиар зохицуулж байна. Эдгээр хуулиудын хүрээнд дээрх патент, гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхийг баталгаажуулах үйл ажиллагаанд мэдүүлэг гаргагчийг төлөөлөх оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааг зохицуулсан байдаг. Патентын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-д , Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т заасны дагуу Оюуны өмчийн газрын даргын 2002 оны 1/120 дугаар тушаалаар Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг анх батласан боловч энэхүү журам нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй хүчин төгөлдөр бус байна.

Монгол Улсын Их Хурлаар баталсан Оюуны өмчийн тухай хуульд Оюуны өмчийн байгууллагын эрх зүйн статус болон чиг үүргийг нэгдсэн байдлаар тодорхойлсон ба тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дах заалтад оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, мөн хуулийн 12.1.14 дэх заалтад оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг батлах гэж оюуны өмчийн байгууллагын чиг үүргийг заасан нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг боловсруулах хууль зүйн үндэслэлийг тодорхойлж байна.

2020 оны 5 дугаар сарын байдлаар нийт 74 итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх олгосноос 7.4 орчим хувь нь хуулийн этгээдэд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах тусгай зөвшөөрөл олгосон байдаг. Үүний 64 хувь буюу нийт 41 итгэмжлэгдсэн төлөөлөгч Монголын оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн холбооны гишүүнчлэлтэй байна.

Оюуны өмчийн байгууллагаас Оюуны өмчийн тухай хууль, Патентын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.16, 27 дугаар зүйл, Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.15, 31 дүгээр зүйлийн 31-д заасны дагуу оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах иргэнийг сонгон шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох ажиллагааны ил тод байдлыг хангах, зохиолч, бүтээл туурвигч, зохион бүтээгч, шинийг санаачлагчдын эрх ашгийг хамгаалах, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх үүрэг, хариуцлагын тогтолцоог тодорхой, нэг мөр болгох шаардлагатай байна.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагаатай холбоотой дараах хүндрэл бэрхшээл тулгарч байна. Тухайлбал:

- оюуны өмчийн байгууллага нь холбогдох дээрх хуулиудын хүрээнд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох заасан байх боловч энэ харилцааг зохицуулсан журам байхгүй;
- оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болсон мэдээллийг мэдээллийн санд тухай бүрд өөрчлөлт оруулаагүйн улмаас мэдээллийн бааз бодит бус;
- оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь мэргэжлийн холбоонд гишүүнчлэлгүй байх нь тэдгээрийн мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тавих боломжгүй байх;
- оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа нь хувь хүний ур чадвартай салшгүй холбоотой явагддаг байтал хуулийн этгээдэд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгосон;
- оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн сонгон шалгаруулалт явуулах нэгдсэн удирдамж, журам байхгүй, Патентын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасан оюуны өмчийн салбарт ажилласан байдлыг тогтоох шалгуур тодорхойгүй;

Дээр дурдсан үндэслэл шаардлагын дагуу 2020 оны 12 дугаар сараас хүчин төгөлдөр мөрдөгдөх Оюуны өмчийн тухай хуульд нийцүүлэн Оюуны өмчийн итгэмжлэгдсэн

төлөөлөгчийн эрх үүрэг, сонгон шалгаруулалт болон мэргэжлийн холбооны гишүүнчлэл болон эрх, үүрэг, мэргэжлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, түдгэлзүүлэх харилцааг зохицуулсан журмын төслийг боловсрууллаа.

### **Хоёр. Журмын бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Журмын төсөл нь 11 бүлэгтэй.

Нийтлэг үндэслэл гэсэн нэгдүгээр бүлгийн хэм хэмжээ журмын төслийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааны зарчмаас бүрдэнэ.

Нэр томъёоны тодорхойлолтын бүлэгт оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа, мэргэжлийн холбоо болон төлөөлүүлэгч зэрэг нэр томъёог тайлбарласан.

Гуравдугаар бүлэгт оюуны өмчийн төрлүүдийн ялгаатай байдлыг харгалзан итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрөлжүүлэн, шаардлагыг өндөржүүлсэн.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сонгох шалгаруулах дөрөвдүгээр бүлэгт шалгалт авах бүрэлдэхүүн, шалгалтын тов, шалгалтын давтамж, шалгалт зохион байгуулах болон шалгалтын комиссын үйл ажиллагааг журамласан.

Мэргэжлийн холбооны чиг үүрэг, мэргэжлийн холбооны зохион байгуулалт, ажлын албаны бүтэц, санхүүгийн бие даасан байдлыг баталгаажуулсан.

Зургадугаар бүлэгт Оюуны өмчийн байгууллагаас шалгалтын комисс байгуулах, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох, түтгэлзүүлэх, хүчингүй болгох, нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, оюуны өмчийн багц сургалтын хөтөлбөр боловсруулах, багц цагын сургалт, давтан сургах ажлыг зохион байгуулах эрх, үүрэг зэргийг зааж өгсөн.

Долдугаар бүлэг нь Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх, нийтлэг үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаанд хориглох зүйлээс бүрдэнэ.

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тохиолдол, сэргээх үндэслэлийг наймдугаар бүлэгт тусгасан.

Есдүгээр бүлэг нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгосон этгээдэд хориглох зүйлээс бүрдэнэ.

Оюуны өмчийн мэргэжлийн үйл ажиллагааны талаар гомдол гаргах асуудлыг аравдугаар бүлэгт зохицуулахаар оруулав.

Арваннэгдүгээр бүлэгт журмын хэрэгжилтэд хяналт тавих байгууллагыг тодорхойлсноос гадна тусгай зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхийг дордуулахгүй байх зорилгоор энэхүү журмыг буцаан хэрэглэхгүй байх заалтыг тусгасан.

### **Гурав. Журмын төсөл батлагдсанаар гарах үр дагавар**

Энэхүү журамд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах үйл ажиллагааны төрөл, сонгон шалгаруулалтыг зарлах, бүртгэх, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн холбооны чиг үүрэг, зохион байгуулалт, оюуны өмчийн байгууллагын эрх, үүрэг, итгэмжлэгдсэн төлөөлөгчид тавигдах шаардлага хүлээх хариуцлагыг тодорхой болгосноор оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал нэмэгдэж, түүнд хяналт тавих боломж бүрдэнэ.

## **ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР**